

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ 2010 оны 6 дугаар сарын 11-ний өдөр

Хичээлийн жил дуусч байгаатай холбогдуулан та бүхэнд талархал илэрхийлье. Энэ хичээлийн жил дахин та бүхний хүүхдүүдэд үйлчилсэндээ баяртай байна. Бид бүхэнд итгэл үзүүлж хүүхдийнхээ боловсрол, тэднийг хөгжүүлэх ажлыг бидэнд даатгасаныг бид нэр төрийн хэрэг гэж хүндэтгэн бахархаж байна. Бид та бүхний ихэнхтэй ирэх хичээлийн жилийн эхний өдөр буюу 2010 оны 8 сарын 23-нд дахин уулзана гэдэгтэй итгэлтэй байна. Манай сургуулиас явж байгаа багш сурагчиддаа ОУДС-д хамт ажиллаж суралцсанд та бүхэнд баярлалаа. Бид та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж та бүхнийг бидэнтэй байнга холбоотой байна гэдэгт итгэлтэй байна. Та бүхэн аян замдаа сайн явж зуны амралтаа сайхан өнгөрүүлээрэй.

Захирал Greg Rayl

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

6 сарын 14	2-р ангийн Кемп аялал Нүхт-өдрөөр
6 сарын 15	1-р ангийн Кемп аялал Тэрэлж Бүүвэйт-өдрөөр
6 сарын 15	Бэлтгэл ангийн Кемп Аялал Монгол Шилтгээн-өдрөөр
6 сарын 16	Нийт сургуулийн спортын өдөрлөг
6 сарын 17	Хичээлийн жилийн сүүлчийн өдөр

Хичээлийн жилийн хаалтын өдөрлөгт эцэг эхчүүд та бүхэн ирж оролцоорой, өдөрлөг өглөө 8:30-д биеийн тамирын заланд болно
Сурагчид 12 цагт тарна

Спортын Өдөрлөг

Эцэг эхчүүд та бүхэн Лхагва гарагт ирж манай Спортын Өдөрлөгт оролцоорой. Сурагчдын энэ өдөр идэх иж бүрдэл хоолны үнийг 6 сарын 15-ны Мягмар гарагийн өглөө ангийн багш нарт нь ирүүлээрэй. ЭББ-н хамт олон сурагчдад мөхөөлдөс тараана.

Кафетерия

Даваа, Мягмар гарагуудад кафетерия хуваарийн дагуу ажиллана. Мягмар гарагийн үдээс хойш сурагчид хоолны тооцоогоо хийж эхлэх боломжтой. Спортын өдөрлөгийн иж бүрдэл хоолны үнийг мөнгөний хариулт буцаахгүйгээр мөнгөө тааруулж ангийн багш нарт Мягмар гарагийн өглөө хураалгана уу. Пүрэв гарагт кафетерия ажиллахгүй тул сурагчид өглөөний снакаа өөрсдөө гэрээсээ авчирна.

ЭББүлгийхэнд Намрын Баярын сугалааны тохиролд Шагнал хандивлах байгууллага хамт олон хэрэгтэй байна.

Манай сургуулийн Намрын Баяр есөн сард болно. Энэ баярын үеэр сугалааны тохиролд олгох шагнал хандивлах байгууллага хамт олон бидэнд хэрэгтэй байна. Өнгөрсөн хугацаанд бид сугалааны тохиролд гоо сайхны салоноор үйлчлүүлэх эрхийн бичиг, бялдаржуулах төвийн гишүүнээр элсэх эрх, оройн хоол идэх урилга, зочид буудалд амрах эрх зэрэг олон шагналуудыг олгодог байсан. Та бүхэн УБ-т бизнес эрхэлдэг бөгөөд Намрын Баярын сугалааны тохиролд шагнал хандивлах хүсэлтэй бол Michele Moller-той michelemoller@yahoo.com хаягаар холбогдоорой.

Номын Сангаас:

Номын сангийн хэд хэдэн ном дутуу байна. Та бүхэн гэртээ ОУДС-ийн номын сангийн ном үлдсэн эсэхийг сайтар шалгаарай. Сургуулийн номын сангийн номнууд баар кодтой бөгөөд тод өнгийн цэгэн наалттай, ISU гэсэн улаан тамга дарагдсан номнууд байгаа. Та бүхэнд баярлалаа.

Хаяж Гээсэн Эд Зүйлс

Сурагчдын хаяж гээсэн хувцас, хоолны сав гэх мэт эзэн нь олдоогүй олон зүйлс бидэнд цуглараад байна. Ирэх долоо хоногуудад хаяж гээсэн зүйлс байвал шалгаарай гэж сурагчдад анхааруулна уу. Хичээлийн жилийн төгсгөлд эзэн нь олдоогүй эд, зүйлсийг бид асрамжийн газарт хандивлах болно.

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Хичээлийн жил бараг дуусах дөхөж байгаа хэдий ч бид хичээлээ заадгаараа зааж, сурагчид шалгалтуудаа өгч зарим хүмүүс буцаж эхэлж байна. Хичээлийн жилийн төгсгөл ихэнхдээ иймэрхүү ажил ихтэй өрнөдөг. Бид 10-р ангийн туршилтын долоо хоногийг амжилттай дуусгалаа. Энэ хичээлийн жилд хичээл сурлагандаа анхаарч амжилттай суралцсан хүүхдүүддээ баяр хүргээрэй.

Ирэх Мягмар гарагт бид цэвэрлэгээ хийж, Лхагва гарагт спортын өдөрлөг зохиож Пүрэв гарагт хичээлийн жилийн сүүлчийн өдөр болно. Сургуулийн альбом болон сурагчдын дүн ирэх долоо хоногт та бүхний гар дээр очно. Пүрэв гарагт хичээл 12 цагт дуусна. Энэ өдөр кафетерия ажиллахгүй.

Та бүхэн амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй. Ирэх долоо хоногт та бүхэнтэй сургууль дээр уулзана гэж найдаж байна.

Дунд Сургуулийн Эрхлэгч, Betsy Hanselmann

ОУДС-ийн 7-р ангийн сурагчид Дэлхийн Байгаль Хамгаалах өдрийн хүрээнд олон улсын хэмжээнд зарласан төслийн уралдаанд тэргүүн байр эзэллээ.

7-р ангийн сурагчид пластик сэдвийн хүрээнд дэлгүүрүүдэд зардаг хальсан уутнууд байгаль орчныг хэрхэн сүйтгэдэг талаар судалсан билээ. Сурагчид маань энэ сэдвээр сурталчилгааны хуудас хэвлэж видео бэлтгэн сургуулийн жүжигчилсэн тоглолт болон авъяастнуудын өдрөөр бусад энэ талаар сурталчилж танилцуулсан. Эдгээр арга хэмжээний үеэр сурагчид дахин хэрэглэж болох даавуун торнууд худалдсан. Манай сургуулийн хамт олон эдгээр торнуудыг худалдан авч хальсан уутны хэрэглээг багасгасан. Даавуун торны худалдаа болон пластикийн хэрэглээг багасгах бусад арга замуудыг нэгтгэн бид “Mongolian Bring Your Own Bag Initiative” төслөө Дэлхийн Байгаль Хамгаалах өдрийн хүрээнд зарласан төслийн уралдаанд явуулсан. (www.projectearth.net)

6 сарын 5-нд Дэлхий Төслийн хамт олон Монгол дахь ОУДС-ийн 7-р ангийн сурагчдын төсөл энэхүү уралдаанд тэргүүн байр эзэлж 500 ам долларын шагнал хүртэх болсоныг дэлхий нийтээр зарласан.

7-р ангийн сурагчид бид дахин хэрэглэх даавуун тор худалдан авч бидний төслийг дэмжсэн бүх хүмүүст талархал илэрхийлж байна. Та бүхнийг даавуун торнуудаа цаашид ч байнга хэрэглэнэ гэдэгт бид итгэлтэй байна. Та нар Project Earth вэб сайтаар орж сурагчдын хийсэн видеог үзэж зургийн цомогтой танилцан байгаль орчныг хамгаалах талаар дэлхийн олон орны сургуулиуд ямар ажил хийж байгаа талаар сонирхоорой.

Баярлалаа. 7-р ангийн хамт олон

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

“Би Өөрчилж Чадна” 5-р ангийн Үзэсгэлэн

Энэ долоо хоногт 5 –р ангийн үзэсгэлэнгийн Гала үдэш амжилттай болж өнгөрлөө. 5-р ангийн Үзэсгэлэн нь Бага сургуулийн хөтөлбөрийн оргил хэсэг нь байдаг бөгөөд энэ үзэсгэлэнгийн үеэр сурагчид сурч мэдсэн зүйлээ тайлагнадаг уламжлалтай. Тэд үзэсгэлэнд бэлтгэж төлөвлөгөө гаргаж, судалгаа хийж мэдээлэл цуглуулан өөрсдийн туршлагын талаар эцэг эхчүүд, багш нар бусад байгууллагын төлөөлөгчдөд презентаци хийж сонирхууллаа. Тэд бусдын амьдралд хэрхэн өөрчлөлт хийж чадсан тухайгаа бидэнтэй хуваалцсан юм. 5-р ангийн сурагчиддаа баяр хүргэе!

Сурагчдын үзэсгэлэнг хийхэд туслалцаа үзүүлсэн багш нар, сургуулийн ажилтнууд, судалгаанд оролцсон байгууллагуудад онцгойлон талархал илэрхийлье:

5-р ангийн багш Ms. Carroll, бага сургуулийн багш нарын хамт олон, Ms. Eret Primary Art, Mrs. Sarantungaa Music, Ms. Selenge Grade 5 TA and Ms Faber PYP coordinator.

Group Mentors: Mr. Chilton, Mrs. Hill, Mrs. Covington, Ms. Munch, Mrs. Dsouza, Ms. Baigalmaa, Dr. Jenner, Ms. Silberberg, Mr. Laws and Ms. Leong

Local Organizations: Bayanzurk Orphanage, Batsumber Retirement Home
Cancer Center, Dolma Ling Community Center Soup Kitchen, Lotus Orphanage, Norwegian Lutheran Mission, US Embassy and World Health Organization

Classic Catering: for food, refreshments and a wonderful chocolate cake.

БИЕИЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС

ОУДС-ийн спортын баг тамирчид

Манай спортын баг тамирчдад шагнал гардуулах анхны хүлээн авалт 6 сарын 4-ний Баасан гарагт Strings ресторанд болж багш, сурагчид, эцэг эхчүүдийн төлөөлөл болох наяд хүн энэ хүлээн авалтанд оролцлоо. Энэ хичээлийн жилд ОУДС-ийг төлөөлж сагс, гар бөмбөг, хөл бөмбөгийн тэмцээнүүдэд амжилттай оролцсон баг тамирчдад баяр хүргэж багийн ахлагчид, дасгалжуулагч багш нар үг хэлсэн. Дунд сургуулийн хичээлийн эрхлэгч Mrs. Hanselmann спортын тэмцээнүүдийг байнга дэмждэгийн хувьд уг арга хэмжээнд оролцож шагнал гардуулсан.

Хүлээн авалтын үеэр спортын тэмцээнүүдийн талаарх слайдийг бид үзэж сонирхсон. Шагнагдсан сурагчид тус бүр гэрчилгээ, медал гардаж авсан.

Сагсны баг тамирчдаас:

Тоглолтоо сайжруулсан тамирчид: Пүрэвбат, Урангоо

Хамгийн дайчин тамирчид: Derryn, Байгаль

Хамгийн үнэ цэнэтэй тамирчид: Jigi, Hiba

Дасгалжуулагчийн Нэрэмжит шагналаар Vasek, Сугармаа нар тус тус шагнагдлаа.

Хөл бөмбөгийн баг тамирчдаас:

Тоглолтоо сайжруулсан тамирчид: Jun Woo, Пүрэвсүрэн

Хамгийн дайчин тамирчид: Mathias, Э. Намуун

Хамгийн үнэ цэнэтэй тамирчид: Derryn, Tiffany

Дасгалжуулагчийн Нэрэмжит шагналаар Пүрэвбат, Jill нар тус тус шагнагдлаа.

Гар бөмбөгийн баг тамирчдаас:

Тоглолтоо сайжруулсан тамирчид: Мишээл, Энх-Эрдэнэ

Хамгийн дайчин тамирчид: Derryn, Mila

Хамгийн үнэ цэнэтэй тамирчид: Jigi, Nalini

Дасгалжуулагчийн Нэрэмжит шагналаар Vasek, Zina нар тус тус шагнагдлаа.

АСАМИС Тамирчдын Талархал

ОУДС-ийн АСАМИС спортын баг тамирчдад шагнал гардуулах анхны хүлээн авалт 6 сарын 4-ний Баасан гарагт Springs ресторанд боллоо. Энэ хүлээн авалтын үеэр багийн ахлагчид болон дасгалжуулагч багш нар маань энэ хичээлийн жилийн спортын арга хэмжээнүүдийн талаар товч үг хэлсэн. Бидний оролцсон тэмцээнүүдийн талаар хийсэн слайдийг үзээд бид оролцсон тэмцээнүүдийнхээ талаар үргэлж санан дурсаж байх болно. Биднийг удирдаж Хятад улсад болсон АСАМИС тэмцээнүүдэд амжилттай оролцсон Mr. Ricketts багшдаа онцгойлон талархал илэрхийлж байна. ОУДС-ийг төлөөлж хаана ч явж байлаа гэсэн сургуулиараа бахархаж нэр төрийг нь өндөрт өргөж явахыг бидэнд байнга сургаж байдаг багшдаа баярлалаа. Энэ хичээлийн жилд өөрсдийн цаг завьг бидэнд зориулан биднийг дасгалжуулж байсан дасгалжуулагч нартаа баярлалаа. Ирэх жилийн АСАМИС тэмцээнүүдэд амжилттай оролцохыг хүсэн ерөөе!

Та бүхэнд баярлалаа.

ОУДС-ийн 2009-2010 оны АСАМИС-н баг тамирчид

Спортын Өдөрлөг 6 сарын 16-ны Лхагва гарагт өглөө 9 цагаас сургууль дээр эхэлнэ. Эцэг эхчүүд та бүхнийг урьж байна. Бага сургуулийн сурагчид 12 цагт, дунд сургуулийн сурагчид 12:30-д спортын арга хэмжээнүүдээ дуусгана. Спортын шагналыг биеийн тамирын заланд 2:20-д гардуулна.

Биеийн тамирын хичээлээр жилийн туршид хийж сурсан дасгалууд болон өөрсдийн спортын ур чадвараа сурагчид энэ үеэр харуулах боломжтой. Спортын уламжлалт арга хэмжээнүүдээс гадна хөгжөөнт тоглоомууд бас хөтөлбөрт орсон байгаа.

Сурагч бүр багт хуваарилагдсан байгаа. Эдгээр багуудыг бид цэнхэр, ногоон, улаан, шар багууд гэж өнгөөр ялгадаг. Энэ өдрийн туршид сурагчид өөрсдийн багтаа оноо авчрах боломжтой. Энэ жилийн спортын өдөрлөг багаар хамтарч ажиллахад гол анхаарлаа хандуулах тул сурагч бүр багийнхаа амжилтанд хувь нэмэр оруулахад чухал үүрэгтэй.

Түүрүүлсэн багт цом гардуулах болно. Анги тус бүрийн авсан оноо нь багуудын ерөнхий дүнд нэмэгдэж нэгдсэн дүн гарна. Өнгөрсөн жилийн ялагчаар Цэнхэр багийн хамт олон шалгарч байсан.

Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч David Ricketts